ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/72 Арвайхээр сум

Арвайхээр-лиг сагсан бөмбөгийн тэмцээнд дэмжлэг үзүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Арвайхээр хотын залуус "Хамтдаа спортоор хичээллэж электрон тамхинаас татгалзъя" уриатай зохион байгуулагдаж буй "Арвайхээр лиг" сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах зардалд дэмжлэг үзүүлж 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Н.Нацагням)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:2024/Alban bichig/Zahiramj-2024